



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.24 № 1/4 ЧАГ/САГ/2013-2014/28/СТЖА-ТӨҮТ

Төсвийн орлогод төвлөрүүлэх  
тухай

Үндэсний аудитын газраас баталсан хуваарийн дагуу "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК-ийн 2012 он, 2013 оны санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар батлагдсан журмыг зөрчин зарим хүнд орон сууцны тэтгэмж, сургалтын төлбөр олгосон зөрчил илэрлээ. Үүнд:

- 2011 онд ТУЗ-ийн гишүүн Х.Володяд 40.0 сая төгрөг, 2012 онд ТУЗ-ийн гишүүн Х.Болдмандалд 30.0 сая төгрөгийн орон сууцны тэтгэмжийг тус тус олгохоор шийдвэрлэж, Хувь хүний орлогын албан татварыг суутган нийт 63.0 сая төгрөгийг олгожээ.

Энэ нь тухайн үед хэрэгжиж байсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 21.4-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨК-ийн "Ажилтан, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх журам"-ын 2.2-д "Компанид нэг жилээс дээш хугацаагаар ажилласан үндсэн ажилтан 2.1-д заагдсан дэмжлэг хүссэн өргөдөл гаргах эрхтэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

- ТУЗ-ийн 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 37/04 дүгээр тогтоолын дагуу гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан С.Адъяасүрэнд гадаадад суралцахад дэмжлэг болгон сургалтын төлбөрт 16.0 сая төгрөг олгожээ.

Энэ нь "Ажилтан, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх журам"-ын 4.1-д "Компанийн ажилтан байгууллагын зардлаар гадаад, дотоодод ажил, албан тушаалтай холбоотой чиглэлээр, эргэн ажиллах гэрээний нөхцөлтэйгээр 2-4 жилийн хугацаатай дээд сургуульд суралцах сургалтад хамрагдаж болно. Энэ тохиолдолд дотоодод 5 сая хүртэл, гадаадад 15 сая хүртэл төгрөгийн сургалтын дэмжлэгийг 1 удаа олгоно" гэж заасныг хэтрүүлэн олгосон байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.1-д “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан алдаа, зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тавина” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Дээрх 64.0 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Төрийн сан банкин дахь УАГ-ын 900000601 тоот дансанд 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлэн, төсвийн орлого болгохыг “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн Гүйцэтгэх захирал П.Маргад-Эрдэнэ, Санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Тэрбиш нарт хариуцуулав.

**АКТЫГ**  
**ТОГТООСОН:**

Санхүүгийн аудитын газрын  
Нэгдүгээр хэлтсийн захирал  
*С. Оюунгэрэл*  
С. Оюунгэрэл

“Ситико Аудит” ХХК-ийн  
Захирал  
*Л. Энхжаргал*  
Л. Энхжаргал

“Ситико Аудит” ХХК-ийн  
аудитын менежер  
*А. Ёндонжамц*  
А. Ёндонжамц

*Төрийн сангийн дарга*

**ЗӨВШӨӨРСӨН:**

“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн  
Гүйцэтгэх захирал  
*П. Маргад-Эрдэнэ*  
П. Маргад-Эрдэнэ

Санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалтын  
газрын дарга  
*Б. Тэрбиш*  
Б. Тэрбиш

*Төрийн сангийн дарга*

*Төрийн сангийн дарга Чигэлэн Аудитын  
Төвөөр 2014.03.07-ны өдөр  
Энэ тоотор зурвсан даан  
Хүргүүлсэн  
Захирал*

*П. Маргад-Эрдэнэ*